



**ХЭНТИЙ АЙМАГ
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/06

Бэрх

**Хариуцлагатай жижүүр
ажиллуулах тухай**

Монгол улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус хотод Сар шинийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан гэмт хэрэг, хэв журмын зөрчил гаргуулахгүй байх ажлыг зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах зорилгоор 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 12-ны өдрүүдэд хариуцлагатай жижүүрүүдийг томилсугай.

2. Хариуцлагатай жижүүрүүдийг томилон үүрэгжүүлж, хяналт тавихыг байгууллагын дарга эрхлэгч нарт, Цагдаагийн тасаг, Захирагчийн ажлын алба, ГТУА 42 дугаар ангийн хариуцлагатай жижүүрүүдтэй байнгын холбоотой ажиллаж, цагийн байдлаа 2 цаг тутам мэдээллэж ажиллахыг байгууллага тус бүрийн томилогдсон хариуцлагатай жижүүрүүдэд үүрэг болгосугай.

3. Хариуцлагатай жижүүр томилсон тушаалыг Захирагчийн ажлын албанд 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 10:00 цагийн дотор ирүүлэхийг байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

4. Гудамж талбайд хөдөлгөөнт эргүүл хийж иргэдийн амгалан тайван байдлыг хангах, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн иргэдийг ар гэрт нь мэдэгдэж зохицуулах арга хэмжээ авах, худалдаа үйлчилгээ эрхэлдэг дэлгүүр ААНэгж Байгууллагын цагийн хуваарьт хяналт тавьж удирдлагаар хангаж ажиллахыг Цагдаагийн дарга хошууч /С.Болорсүх/-д даалгасугай.

5. Байгууллагуудтай холбогдох утасны дугааруудыг хавсралтаар баталсугай.

ЗАХИРАГЧ



Ч.ЭНХЖАВХЛАН